



ЖУЛЯНАНА САЛМАСО:

Өөр хаана ч байгаагүй өвөрмөц архитекторын бүтээлийг Монголд хийж өгөхийг хүсч байна

Түрүүч нь I нүүрт

Энэ удаад барих гэж буй загварын их дэлгүүрийн онцлог нь тухайн брэндийн бүтээгдэхүүнүүдийг харьцангуй хямдралтай үнээр худалдаалах болно. Энэ мэтчилэн дурдвал олон улс оронд ажиллаж, багагүй зүйлийг хийсэн шүү.

-Та болоод танай багийнхан архитекторын ажлыг олон улс оронд хийдэг нь их сонирхолтой санагдлаа. Ажлаа эхлэхээс өмнө тухайн орны хот төлөвлөлт болоод соёл уламжлалтай нь ч танилцах хэрэгтэй болдог уу?

-Тэгэлгүй яахав. Жишээлбэл бид архитекторын чиглэлээр Эстон ул-

сад судалгаа хийж байгаа. Тухайн улсын хот төлөвлөлтийг нэлээд судалсны дүнд хотын төвд нуурын эрэг орчмыг гайхалтай шийдлээр тохижуулах ажлыг эхлүүлэх төлөвлөгөөтэй байгаа. АНУ-ын Жоржио мужид байдаг галт тэрэгний буудлын архитекторыг бид хэдэн жилийн өмнө хийсэн. Тэр хотын хүн ам нь галт тэргээр их үйлчлүүлдэг. Хотын нэг захад гэр нь, нөгөө захад ажил нь байдаг гэх мэтээр хүн амын судалгааг харгалзан хийх хэрэгтэй болдог.

-Манай улсад түр саагах хугацаанд та юу ажиглав. Архитекторын ямар шийдэл дутагдаж байгаа юм шиг санагдсан бэ?

-Монгол хүмүүсийн аж төрөх орчныг сайжруулах



мэдэхгүй байна.

-Монгол хүмүүс, Улаанбаатарынхныг хараад танд төрсөн анхны сэтгэгдлийг сонирхож болох уу?

-Их нөхөрсөг бас боловсролтой хүмүүстэй уулзсандаа баяртай байна. Надад таалагдсан нэг зүйл гэвэл монголчууд их ирээдүйтэй, түүндээ хүмүүс нь их итгэл үнэмшилтэй байгаа нь сонирхолтой санагдсан. Ирээдүйдээ итгэлтэй байгаа нь маш сайхан гэвч ямар ч хөгжил хотоос эхэлдэг шүү дээ. Ром, Франц зэрэг улсад 2000 жилийн тэртээ баригдсан эртний барилгууд нь үлдсэн байдаг. Тэд шинэ барьсан барилгаасаа илүүтэйгээр эртний хуучин барилгуудаа хайрлаж, түүгээрээ хотынхоо өнгө төр-

хэрэгтэй санагдсан. Улаанбаатар хотод хийх гэж байгаа ажлынхаа хүрээнд энэ хотод хүмүүс ихээр цуглардаг зарим нэг газрыг судлах хэрэгтэй байх гэж бодсон. Хэрвээ танай улсад хийх төсөл маань төлөвлөгөөний дагуу явбал улс оронд давтагдаж байгаагүй өвөрмөц шийдэл бүхий архитекторын бүтээлийг хийж өгөхийг хүсч байна. Харамсалтай нь, яг одоогийн байдлаар би энэ хотод хаана нь юу байдгийг сайн

хийж тодорхойлдог. Ромд хуучин барилгуудыг нурааж, шинэ барилга барих ажил нэг үе өрнөсөн. Гэвч тэд энэ нь оновчтой шийдэл биш болохыг удалгүй ойлгож мөн л эртний хуучны барилгуудаараа өнгө төрхөө тодорхойлсон байдаг. Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар улс орон бүрт шинэ барилга байгууламж ихээр барьсан байдаг ч тэд усталгүй үлдсэн хуучин барилгуудаа шинээсээ илүү анхаарал хандуулсан байдаг.




-Эртний барилгууд хотын өнгө төрхийг чимэх гайхалтай шийдэл болдог ч контенперари буюу орчин үеийн архитекторын бүтээлүүд тэдэнтэй зэрэгцэн байрлаж бас болно биз дээ?

/Тэрээр хуучин барилгын дээвэр дээр орчин үеийн шийдэл бүхий station байрлуулсан зураг төслийг дэлгэн үзүүлэв/


-Флоренц бол дэлхийн хамгийн үзэсгэлэнтэй барилгатай хот. Учир нь, эртний гайхалтай барилгууд энэ хотод байдаг юм. Гэсэн ч хот төлөвлөлтийнхөө төлөвлөгөөнд тэд орчин үеийн шийдэл бүхий барилгуудыг мөн барих сонирхолтой. Энэ эртний байшингийн дээвэр дээр бид орчин үеийн архитекторын шийдэл бүхий тавцанг байрлуулсан. Энэ тавцан дээр хүмүүс гарч алжаалаа тайлж салхилна, дээвэр дээр дэлгүүр худалдаа төрөл бүрийн үйлчилгээ байж болно. Мөн энэхүү дээвэрээр дамжин сүм рүү орох боломжтой байдлаар шийдсэн. Энэхүү тавцан дээр байгаа хүмүүсийг холоос харвал яг л хөвж байгаа юм шиг харагддаг. Үүнийг орчин үеийн архитекторын нэг жишээ гэж хэлмээр байна.

-Манай улсад та бүгдийн урлах гайхалтай шийдэл бүхий архитекторын бүтээлийг харахыг тэсэн ядан хүлээж байна. Амжилт хүсье.

-Улаанбаатар хотын төв хэсэгт байрлах нэгэн барилгын зураг төсөл дээр хэдэн цагийн хугацаанд а иллалаа. Хэрэв төлөвлөсний дагуу ажил хэрэгжиж эхэлбэл та бүгд энэ барилгыг тун удахгүй харах болно.



Хадгаламж Банк
Харилцагч эргэлтэнд




АТМ
Автомат бэлэн мөнгөний машин

Та картнаас - Карт руу
- Данс руу

МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ ХИЙХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

100% Монголын хөрөнгө оруулалттай банк
100% онлайн банк



1925

ЭРДЭС БАЯЛГИЙН
БИЗНЕС ХӨТӨЧ

- + Эрдэс баялгийн салбарын мэдээлэл
- + Ашигт малтмалын бүтээгдэхүүний зах зээлийн мэдээлэл
- + Геологи, уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл
- + Хангав нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээлэл
- + Геологи, уул уурхайн баримт бичгийн бүрдүүлэлт



Эрүүл сэтгүүлзүйн төлөө!

Манай сонин IV үндэсний дагуу ажил хэрэгжиж эхэлбэл та бүгд энэ барилгыг тун удахгүй харах болно.